



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 426

Улаанбаатар хот

“Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах стратеги” батлах тухай

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Засгийн газрын 2005 оны 245 дугаар тогтоолоор батлагдсан “Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах стратеги”-ийг 1 дүгээр, Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах стратеги”-ийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал)-т даалгасугай.

3. Стратегид тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусгахын зэрэгцээ олон улсын төсөл, хөтөлбөрт тусгаж санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д үүрэг болгосугай.

4. “Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах стратеги”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

САЙД



Н.УДВАЛ

D:\barim\tushaal

082493

ХИМИЙН БОДИСЫН ХҮНИЙ ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ /2015-2018/

Нэг. Стратеги боловсруулах үндэслэл

Дэлхийн зах зээлд 10 сая гаруй нэр төрлийн химийн бодис бүртгэгдээд байгаагаас 70 мянга гаруй нь ахуйн хэрэгцээнд өргөн ашиглагдаж, 10 мянга гаруй нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлдэг бол 200 гаруй химийн бодис нь хорт хавдар үүсгэх үндсэн шалгаан болдог байна.

Монгол улсын хэмжээнд уул уурхай болон бусад салбарт давхардсан тоогоор 8000 нэр төрлийн 10000 орчим тонн химийн бодис ашиглагдаж байгаагаас 100 гаруй нэр төрөл нь агаар, 1000 гаруй нэр төрөл нь ус, хөрсийг бохирдуулж байна¹. Мөн улсын хэмжээнд бүрэн бус тоогоор 3000 гаруй га талбай бүхий 450 цэгт химийн бодис ил задгай хаягдаж, хог хаягдлаар 10 мянга гаруй га газар, химийн бодис, нефтийн бүтээгдэхүүнээр 4000 га газар бохирдсон байна.

Хүүхдийн тоглоом болон сав суулга, ахуйн цэвэрлэгээний бодис болон өдөр тутмын хэрэглээний бараа бүтээгдэхүүнд формальдегид, поливинилхлор, хар тугалга зэрэг хортой химийн бодис агуулагдах, хуванцар болон хүнсний нийлэг сав, баглаа боодол стандартын шаардлага хангахгүй байх, хорт хавдар үүсгэгч формальдегид, стерин зэрэг бодисууд илрэх, жил бүр 440 000 м³ бохир усыг цэвэрлээгүй гол, горхи руу хийх зэрэг химийн бодисын бохирдолтой холбоотой олон асуудлууд бидний өдөр тутмын амьдралд тулгарсаар байна.

Иймээс химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх эрсдлийг судлах, түүнээс урьдчилан сэргийлэх, нотолгоонд тулгуурласан цэгцтэй арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлэх зорилгоор “Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах стратеги”-ийг боловсруулав.

Хоёр. Стратегийн зорилго, зорилт

2.1. Зорилго:

Химийн бодисын зохистой хэрэглээний орчин бүрдүүлж, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд стратегийн зорилго оршино.

2.2 Зорилт:

- 2.2.1 Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хууль эрх зүйн орчины хэрэгжилтийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх
- 2.2.2 Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, химийн бодисыг зүй зохистой хэрэглэх дадал эзэмшүүлэх

¹Химийн хортой болон аюултай бодисын ашиглалт, хамгаалалтын улсын үзлэг 2008 он

Гурав: Стратегийг хэрэгжүүлэх зарчим

3.1 Стратегийг хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтална:

- 3.1.1 Хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, салбар хоорондын үйл ажиллагааны уялдаа, холбоонд тулгуурлах;
- 3.1.2 ДЭМБ болон олон улсын чиг хандлага, удирдамжинд түшиглэсэн байх;
- 3.1.3 Нийгмийн түншүүд, иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын хамтын ажиллагаанд түшиглэх;

Дөрөв. Стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн

4.1 Стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 4.1.1 Химийн бодис, түүнтэй холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг сайжруулах
- 4.1.2 Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн хяналт, тандалтын тогтолцоог үнэлэх
- 4.1.3 Химийн бодис, түүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх
- 4.1.4 Байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, боловсон хүчний чадавхыг сайжруулах

Хүрэх үр дүн:

Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулснаар хууль, эрхзүйн орчин, хяналт, тандалтын тогтолцоо бэхжинэ

4.2 Стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

- 4.2.1 Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх судалгааны ажлыг өргөжүүлэх
- 4.2.2 Химийн бодисын хэрэглээнээс үүсэх эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сөрөг нөлөөллийг багасгахад аж ахуйн нэгж байгууллага, иргэд, хувь хүнд чиглэгдсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх
- 4.2.3 Химийн бодистой харьцах аюулгүй ажиллагаа болон хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг тогтмолжуулах, түүнд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг татан оролцуулах
- 4.2.4 Химийн бодисын сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх
- 4.2.6 Хордлогын үед хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах

Хүрэх үр дүн:

Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг шат дараатай хэрэгжүүлж, хүн ам, ажилчдын химийн бодисыг зүй зохистой хэрэглэх аюулгүй байдлын мэдлэг, эмнэлгийн тусламж үйлчилгээ сайжирсан байна.


Тав. Стратегийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

5.1 Хэрэгжүүлэх хугацаа: 2015 – 2018 он

5.2 Санхүүжилт:

- 5.2.1 Улсын болон орон нутгийн төсөв
- 5.2.2 Эрүүл мэндийг дэмжих сан

- 5.2.3 Олон улсын байгууллагын төсөл, стратеги
 5.2.4 Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр



Зургаа. Стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

6.1 Үндэсний болон орон нутгийн хэмжээнд:

- 6.1.1 Үндэсний стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох байгууллагын оролцоотойгоор явуулна.
 6.1.2 Үндэсний стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг 6.2-т тусгасан шалгуур үзүүлэлтийн дагуу хийнэ.

6.2 Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт		2014 оны суурь түвшин	2016 онд хүрэх түвшин	2018 онд хүрэх түвшин
Үндэсний хэмжээнд гарсан химийн бодисын хордлогын хувь /хүн амд/		60 хувь	40 хувь	20 хувь
Хордлогын тусламж мэргэшүүлэх оролцож мэдлэг олж авсан яаралтай үзүүлэх сургалтад	Эмч нарын эзлэх хувь	10 хувь	30 хувь	50 хувь
	Сувилагч болон бусад мэргэжилтний эзлэх хувь	10 хувь	20 хувь	30 хувь
	Ажилчдын эзлэх хувь	10 хувь	40 хувь	100 хувь
	Иргэдийн эзлэх хувь	5 хувь	10 хувь	30 хувь
Хордлогын яаралтай тусламж, үйлчилгээнд хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмжийг шинэчилсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн тоо		10 хувь	20 хувь	40 хувь


6.3 Үр дүнгийн шалгуур үзүүлэлт:

Шалгуур үзүүлэлт	2014 оны суурь түвшин	2016 онд хүрэх түвшин	2018 онд хүрэх түвшин
УБ хотын химийн цочмог, хүнд хордлогын өвчлөл /10 000 хүнд/	560	300	100
УБ хотын химийн хордлогын шалтгаант нас баралт /100 000 хүнд/ Жич: Хордлогын яаралтай тусламж үйлчилгээний төвийн үнэлгээгээр	0.11	0.05	0.02

Эрүүл мэндийн сайдын 2014 оны
 12 сарын 05 өдрийн 4076 дугаар
 тушаалын 2 дугаар хавсралт

**ХИМИЙН БОДИСЫН ЭРҮҮЛ МЭНДЭД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ
 СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ /2015-2018 он/**

№	Үйл ажиллагаа	Хариуцаж хийх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Шалгуур үзүүлэлт	Хугацаа
Зорилт 1. Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хууль эрх зүйн орчины хэрэгжилтийг хангах, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх					
<i>Химийн бодис, түүнтэй холбогдох хууль эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг сайжруулах</i>					
1.1	Химийн бодисын хордлогыг тандах, бүртгэх, мэдээлэх журмын дагуу химийн бодисын хордлогын мэдээг авч, нэгдсэн мэдээллийг гаргана	НЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ	Нэгдсэн мэдээлэл гарна	2015
1.2	Химийн бодисын эрүүл мэндийн нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний аргачлал боловсруулах	НЭМҮТ	ЭМЯ БОНХЯ	Аргачлал батлагдсан байна.	2015
<i>Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн хяналт, тандалтын тогтолцоог үнэлэх</i>					
1.3	Химийн бодисын үйлдвэрлэлийн осол, хурц болон архаг хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгааны үнэлгээ хийх	НЭМҮТ	ХЯ	Үнэлгээний тайлан гарсан байна	2015
1.4	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын	НЭМҮТ	ҮХХААЯ ЭМЯ	Үнэлгээний тайлан гарсан байна	2016

	бохир ус цэвэрлэх байгууламжийн хортой болон аюултай химийн бодисын цэвэрлэгээний түвшинд үнэлгээ хийх				
1.5	Хүн амын дунд химийн бодисын сөрөг нөлөөллийн тандалт судалгааг аймаг, хотын хэмжээнд хийх	НЭМҮТ	ХАХНХЯ	Судалгааны тайлан гарсан байна	2016
<i>Химийн бодис, түүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх</i>					
1.6	Химийн бодисын эрүүл мэндийн нөлөөллийн судалгааны нэгдсэн сан бий болгох	НЭМҮТ	БОНХЯ УУЯ	Нэгдсэн сантай болсон байна	2015- 2016
1.7	Хор, хордлого судлалын эрүүл мэндийн үндэсний нэгж бий болгох	ЭМЯ	НЭМҮТ	Нэгж бий болгох тушаал гарсан байна	2015- 2016
<i>Байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, боловсон хүчний чадамжийг сайжруулах</i>					
1.8	Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр эрдэм шинжилгээний хурал, үндэсний форум, зөвлөлгөөнийг зохион байгуулах	НЭМҮТ	ЭМЯ БОНХЯ	Үндэсний форум, зөвлөгөөний тайлан гарсан байна	2015- 2018
1.9	Салбар хоорондын уялдаа холбоог бэхжүүлэх нэгдсэн төлөвлөгөө	ЭМЯ	НЭМҮТ	Уулзалтын тайлан гарсан байна	2015- 2018

	гаргаж, хамтын ажиллагааг өргөжүүлэх уулзалтуудыг зохион байгуулах				
1.10	Химийн бодисын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр олон улсын сургалт, уулзалт, форум зохион байгуулах	НЭМҮТ	ЭМЯ БОНХЯ	Тайлан гарсан байна	2015- 2018
Зорилт 2. Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, химийн бодисыг зүй зохистой хэрэглэх дадал эзэмшүүлэх					
<i>Химийн бодисын хэрэглээнээс хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх судалгааны ажлыг өргөжүүлэх</i>					
2.1	Орчноос хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж буй химийн бодисын эх үүсвэрийг тогтоох, сөрөг нөлөөллийн хэмжээг тодорхойлох	НЭМҮТ	ЭМЯ БОНХЯ	Судалгааны тайлан гарсан байна	2015
2.2	Хот, суурин газрын ундны усыг бохирдуулж байгаа химийн бодисын эх үүсвэрийг тодорхойлох	НЭМҮТ	АЗАА, НЗАА, АМХГ, НМХГ	Судалгааны тайланг мэргэжлийн байгууллагуудад хүргүүлсэн байна	2015
2.3	Монгол хүний биологийн сорьцон дахь хүнд металлын лавлагаа түвшинг тогтоох	НЭМҮТ	ЭМЯ	Үзүүлэлтийн гарын авлага гарсан байна	2016
2.4	Химийн бодисын хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг судлах	НЭМҮТ	ЭМЯ БСШУЯ	Судалгааны тайланг мэргэжлийн байгууллагуудад хүргүүлсэн байна	2016
2.5	Хүн амын дунд химийн бодисын сөрөг нөлөөллийн	НЭМҮТ	БОНХЯ ХЯ ХЭМСТ	Судалгааны тайланг мэргэжлийн	2016– 2018

	тандалт судалгааг аймаг, хотын хэмжээнд хийх			байгууллагуудад хүргүүлсэн байна	
2.6	Уул уурхайн бүс нутгийн иргэдийн химийн бодист өртөх байдал, хордлогын түвшинд тандалт судалгаа хийх	НЭМҮТ	БОНХЯ УУЯ	Судалгааны тайланг мэргэжлийн байгууллагуудад хүргүүлсэн байна	2015-2016
2.7	Химийн бодис зөөвөрлөж ирсэн савыг ахуйн зориулалт болон хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх, хадгалах сав болгон хэрэглэх, түүнээс үүсэх химийн хордлогын судалгаа хийх			Судалгааны тайланг мэргэжлийн байгууллагуудад хүргүүлсэн байна	2015-2016
<i>Химийн бодисын хэрэглээнээс үүсэх эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, сөрөг нөлөөллийг багасгахад аж ахуйн нэгж байгууллага, иргэд, хувь хүнд чиглэгдсэн урьдчилан сэргийлэх цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэх</i>					
2.8	Химийн бодисын хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх хүн амын мэдлэг, дадал, хандлагыг өөрчлөх сургалт, сурталчилгаа явуулах, үр дүнд үнэлгээ өгөх	НЭМҮТ	ЭМЯ	Тайлан гарсан байна	2015-2018
2.9	Химийн бодистой ажиллагсдад хор судлалын сургалт зохион байгуулах	НЭМҮТ	ЭМЯ, ХЯ, ЭМХТ	Тайлан гарсан байна	2015-2016
<i>Химийн бодистой ажилладаг, түүнд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудад химийн бодисыг зүй зохистой хэрэглэх дадал эзэмшүүлэх</i>					
2.10	Химийн бодистой зүй зохистой харьцах талаар олон нийтэд зориулсан гарын	НЭМҮТ	ЭМЯ БОНХЯ	Гарын авлага, сургалтын хөтөлбөр, сурталчилгааны материал	2015-2018

	авлага, сургалт сурталчилгааны материал бэлтгэх, түгээх			хэвлүүлэн түгээсэн байна	
2.11	Эмч, мэргэжилтнүүдэд зориулсан химийн бодисын хордлогын яаралтай тусламжийн гарын авлага боловсруулах	НЭМҮТ	ЭМЯ	Гарын авлага гарсан байна	2015
<i>Химийн бодистой харьцаж ажиллах, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх сургалт сурталчилгааг тогтмолжуулах, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг татан оролцуулах</i>					
2.12	Химийн аюулгүй байдлыг хангах хамт олны санаачлагыг дэмжих хөдөлгөөнийг өрнүүлэх, мэдээллийн хэрэгслэлээр сурталчлах	ЭМЯ,	БОНХЯ ХЯ НЭМҮТ АЗДТГ НЗДТГ	Тайлан гарсан байна ТВ, радиогийн нэвтрүүлэг гарсан байна	2015- 2016
2.13	Химийн аюулгүй байдал, ахуйн химийн бодисын зөв зохистой хэрэглээний талаарх мэдээллийг олон нийтийн радио, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан олон нийтэд түгээх	НЭМҮТ	ЭМЯ, БОНХЯ	ТВ, радиогийн нэвтрүүлэг гарсан байна	2015- 2018
<i>Химийн бодисын сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх</i>					
2.14	Пестицидийн аюулгүй байдлын менежментийг боловсронгуй болгож, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлдэггүй шинэ	НЭМҮТ	ЭМЯ ҮХХААЯ БОНХЯ ХЭМСТ	Шинэ технологи нэвтэрсэн байна	2015- 2016

	дэвшилтэт технологийг практикт нэвтрүүлэх				
2.15	Химийн бодис зөөвөрлөж ирсэн савыг ахуйн зориулалт болон хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх, хадгалах сав болгон хэрэглэх, түүнээс үүсэх химийн хордлогын талаарх сэрэмжлүүлэх, иргэдэд мэдээлэл, мэдлэг олгох	НЭМҮТ	ЭМЯ ҮХХААЯ БОНХЯ	ТВ, радиогийн нэвтрүүлэг гарсан байна	2015
2.16	Химийн бодисын хяналт судалгааны лабораториудыг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх	ЭМЯ	МХЕГ БОНХЯ ХЯ	НЭМҮТ-ийн лабораторт тоног төхөөрөмж суурилагдсан байна	2015- 2018
<i>Хордлогын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах</i>					
2.17	Химийн бодис болон хүнд металлын хордлогын оношилгоо, эмчилгээний удирдамжийг боловсруулах	ЭМЯ	НЭМҮТ ХЯТҮТ	Удирдамж батлагдсан байна	2015- 2016
2.18	Химийн бодисын хордлогын үеийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийн сургалтыг эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохион байгуулах	НЭМҮТ	ЭМЯ ХЯТҮТ	Сургалтын тайлан гарсан байна	2015